<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,640,800.00</b>	<b>24,202,254.70</b>
210401	Бичиг хэрэг	3,029,200.00	2,804,627.70
210402	Тээвэр, шатахуун	13,672,800.00	13,530,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,938,800.00	1,872,877.00
210404	Ном, хэвлэл	0	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,500,000.00	4,494,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	1,500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>35,377,900.00</b>	<b>34,381,200.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	21,800,000.00	21,769,600.00
210602	Тавилга	1,200,000.00	1,200,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0	0
210604	Урсгал засвар	12,377,900.00	11,411,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,720,000.00</b>	<b>6,120,000.00</b>
210701	Гадаад албан томилолт	0	0
210702	Дотоод албан томилолт	7,720,000.00	6,120,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0	0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,690,400.00</b>	<b>1,594,140.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	200,000.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	284,400.00	232,015.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	296,000.00	283,125.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	79,000.00
210807	Газрын төлбөр	800,000.00	800,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>61,836,800.00</b>	<b>59,037,484.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,836,800.00	46,144,934.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,000,000.00	12,892,550.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>25,902,900.00</b>	<b>25,902,892.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>25,902,900.00</b>	<b>25,902,892.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,202,900.00	25,202,892.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	700,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>339,197,000.00</b>	<b>163,863,900.00</b>
223001	Бусад хөрөнгө	339,197,000.00	163,863,900.00
224001	Стратегийн нөөц хөрөнгө	0	0
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>95,000,000.00</b>	<b>93,010,277.00</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	95,000,000.00	93,010,277.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,204,616,000.00</b>	<b>1,159,396,632.54</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>968,860,600.00</b>	<b>1,048,650,925.54</b>
320001	Орон нутгийн төсвөөс	834,394,800.00	914,185,125.54
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	134,465,800.00	134,465,800.00
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>235,755,400.00</b>	<b>110,745,707.00</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,000,000.00	110,745,707.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	195,755,400.00	0

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	76,784,138.57
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	224,181,862.60
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>80</b>	<b>52</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>2</b>	<b>2</b>
610001	Төсвийн байгууллага	2	2
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>39</b>	<b>25</b>
620001	Удирдах ажилтан	9	9
620002	Гүйцэтгэх ажилтан	12	12
620003	Үйлчлэх ажилтан	18	4
620004	Гэрээт ажилтан	0	0
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>39</b>	<b>25</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	10
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	21	7
650010	Гэрээт ажилтан	0	0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8	8

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>52,311,432.23</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>52,311,432.23</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>45,937,891.20</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,736,000.00</b>
210101	Үндсэн цалин	1,736,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>175,000.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	175,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,171,620.00</b>
210401	Бичиг хэрэг	0
210402	Тээвэр, шатахуун	3,141,620.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,667,700.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,667,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>31,187,571.20</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,187,571.20
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,373,541.03</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>6,373,541.03</b>
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	6,373,541.03
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>45,937,891.20</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>45,937,891.20</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	29,399,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,598,838.20
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,782,920.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,156,633.00
131106	Хаагдсан данс	0
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	0
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>-6,373,541.03</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,373,541.03
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Могод сумын Засаг даргын тамгын газар нь Засгийн газар, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүд, Төр засгийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, Төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх, олон улсын байгууллагаас хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зөв зохистой ашиглан хэрэгжүүлэх, иргэдийн оролцоо ил тод байдлыг хангах, иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, хүн амаа өсгөх, сум орон нутгаа хөгжүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн тодорхой үр дүнд хүрэх зорилт тавин ажиллажээ.

ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Сумын Засаг даргын Тамгын газар нь сумын ИТХ, Засаг даргын үйл ажиллагааны зорилт чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн мэргэжлийн зөвлөгөө дэмжлэгээр хангах

- Төрийн үйлчилгээг чанар хүртээмжтэй шуурхай хүргэх
- Нутгийн захиргааны байгууллагуудыг бодлогоор дэмжих, эрх зүйн шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хангах
- Шийдвэрийн биелэлтэд хяналт шинжилгээ хийж, ололт амжилтыг урамшуулах, алдаа дутагдлыг засаж залруулах, сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг арга зүйн зөвлөмжөөр ханган төрийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорилт гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, орон тоо байхгүй аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт дотоод аудитын алба гүйцэтгэж байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Могод сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр захирамжаар баталсан байна.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Могод сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,193,131.1 төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>Мөнгөн хөрөнгө</b>	229,505.00	287,843.90	58338.9
<b>Авлага</b>	253,522.50	202,642.70	-50879.8
<b>Бараа материал</b>	335,213.30	81,152.80	-254060.5
<b>Үндсэн хөрөнгө</b>	3,553,141.80	1,606,612.10	-1946529.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,371,382.60</b>	<b>2,178,251.50</b>	-2193131.1
<b>Өр төлбөр</b>		1385.3	1385.3
<b>Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	4371382.6	2176866.3	-2194516.3
	<b>4371382.6</b>	<b>2178251.5</b>	-2193131.1

Эх сурвалж: Могод сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 229,505.0 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 287,843.9 мянган төгрөг болж өмнөх оноос 58,338.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мян.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт, бууралт
Хоршоо хөгжүүлэх сан	31,621.1	37,677.2	6,056.1
Төрийн сангийн харилцах	146,347.3	63,662.1	-82,685.2
ОНХсан	7,763.8	145,969.9	138,206.1
ЖДҮДСан	29,548.1	39,653.2	10105.1
ЭМТ	13,343.6		-13,343.6
БХСан	880.9	881.6	0,7
Дүн	229505,0	287,843.9	58,338.9

Эх сурвалж: Могод сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 229,505.0 мянган төгрөг нь орон нутгийн ерөнхий орлогын дансны 63,662.1 мянган төгрөг нь орон нутгийн орлогын давсан орлого, орон нутгийн хөгжлийн санд 145969.9 мянган төгрөг нь малын хөлийн татвар болон хэрэгжээгүй төсөл арга хэмжээний үлдэгдэл байна.

Төсөл сангуудын үлдэгдэлд сум хөгжүүлэх сангийн 37677.2, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан 39,653.2, байгаль хамгаалах санд 881.6 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл тус тус төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

### 3.5.2 Авлага

Авлага Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. дансны эхний үлдэгдэл 253,522.5

мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 188,642.7 мянган төгрөг болж, 64,879.8 сая төгрөгөөр буурсан байна.

**Хүснэгт № 2 Авлагын үлдэгдэл /мян.төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагаас авах авлага	60895.5	82,769.7	21,874.2
Хүмүүсээс авах авлага	192626.9	119,872.9	-72,754.0
Зээлийн авлага			
<b>Дүн</b>	<b>253522.5</b>	<b>202,642.7</b>	<b>50,879.8</b>

Эх сурвалж: Могод сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Байгууллагаас авах авлагад хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн 184,541.0 мянган төгрөг, ЖДҮД сангийн 4,101.6 мянган төгрөгийн авлага, орон нутгийн хөгжлийн сангийн 2022 онд хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан ч хэрэгжээгүй 1 төсөл арга хэмжээний 14,000.0 мянган төгрөгийн авлага байна.

**3.5.3 Урьдчилгаа**

Урьдчилгаа данс эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

**3.5.4 Бараа материал**

Бараа материалын ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ эхний үлдэгдэл 215,658.8 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 335,143.3 мянган төгрөг болж, 119.5 мянган төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт № 3 Бараа материалын үлдэгдэл /мян.төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Эм боох материал	31,528.0	0	-31,528.0
Бичиг хэрэг	9,492.6	3,036.7	-6,455.9
Аж ахуйн материал	63,159.9	23,224.0	39,935.9
Сэлбэг хэрэгсэл	2,636.5	0	-2,636.5
Түлш, шатах тослох материал	1,310.0	0	-1,310.0
Барилгын засвар	928.7	0	-928.7
Хүнсний материал	8,310.9	0	8,310.9
Бусад хангамж	216,521.4	53,566.9	-162,954.5
Нөөцүн бараа	10,360.0	10,360.0	0
Мал амьтад	1,325.2	1325.2	0
<b>Дүн</b>	<b>335,213.3</b>	<b>81,152.8</b>	<b>254,060.5</b>

Эх сурвалж: Могод сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 47,745.9, хандив тусламжаар 4,150.0 төгрөгийн бараа материалыг авч, тайлант онд 48636.7 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулж, шилжүүлгээр болон бүтцийн өөрчлөлтөөр тусгай шилжүүлгийн байгууллагын 257,319.7 төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, 81152.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нийт бараа материалын үлдэгдлийг байгууллагаар харуулбал

**Хүснэгт № 4 Бараа материалын үлдэгдэл байгууллагаар**

/мян.төгрөг/

д/д	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
1	ИТХ	8,271.9	3,893.7	-4,378.2
2	ЗДТГ	59,261.7	65,343.0	6,081.3
3	Хүн эмнэлэг	120,142.0	0	-120,142.0
4	Цэцэрлэг	43,177.9	1,000.0	-42,177.9
5	Сургууль	78,138.7	556	77,582.7
6	Соёлын төв	15,860.9	0	-15,860.9
7	Сум хөгжүүлэх сан			
	ЖДҮДС	10360	10360	0
	Дүн	335,213.3	81,152.8	254,060.5

Нийт бараа материалын бүтцийн өөрчлөлтөөр Соёлын төв 15,860.9, Сургууль 78,138.7 төгрөг, цэцэрлэг 43,177.9 төгрөг, ЭМТ 140,142.0 төгрөг нийт 257,319.7 мянган төгрөгийг хөрөнгийг шилжүүлжээ.

### 3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 5,013,306.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1,606612.1 мянган төгрөг болж, 3,406,694.8 мянган төгрөгөөр буурсан байна.~~

Хүснэгт № 5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мян.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	3,768,399.60	1,923,216.40	-1,845,183.20
Авто тээврийн хэрэгсэл	246,230.60	164,640.00	-81,590.60
Машин тоног төхөөрөмж	499,787.30	167,602.50	-332,184.80
Тавилга, аж ахуйн эд хогшил	267,718.80	142,925.50	-124,793.30
Бусад үндсэн хөрөнгө	73,892.30	37,796.30	-36,096.00
Ном	38,334.20		-38,334.20
Программ хангамж	8,200.00	3,100.00	-5,100.00
Бусад биет бус хөрөнгө	110,744.00	134,334.00	23,590.00
<b>Дүн</b>	<b>5,013,306.90</b>	<b>2,573,614.70</b>	<b>-2,439,692.10</b>

Эх сурвалж: Могод сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 22,969.6, хандив тусламжаар 167,014.5 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн, бүтцийн өөрчлөлтөөр тусгай зориулалтын шилжүүлгийн 2,629,676.3 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлжээ.

Хүснэгт № 6 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар

/мян.төгрөг/

д/д	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
1	ИТХ	19,848.10	19848.1	0.00
2	ЗДТГ	2,363,782.50	2,553,766.60	189,984.10
3	Хүн эмнэлэг	759,263.10		-759,263.10
4	Цэцэрлэг	519,814.50		-519,814.50
5	Сургууль	1,112,414.50		-1,112,414.50

6	Соёлын төв	238,184.20		-238,184.20
	Дүн	5,013,306.9	2,573,614.70	-2,439,692.20

Үндсэн хөрөнгийн дансны бүтцийн өөрчлөлтөөр хасагдсан байгууллагыг авч үзвэл Соёлын төв 238,184.2, Сургууль 1,112,414.5, Цэцэрлэг 519,814.5, ЭМТ-ийн 759,263.1 мянган төгрөгийг хөрөнгийг шилжүүлжээ.

### 3.5.7 Өр төлбөр

Тайлан онд өр төлбөрийн дансанд шинээр ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлд~~ 12,722.3 мянган төгрөгийн өглөг нэмэгдэж үлдэгдлээр тайлагнасан байна.

#### Хүснэгт №7 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
ЗДТГ		1,385.2	1,385.2
Сургууль		11,337.0	11,337.0
Байгууллагаас авах авлага			
Хүмүүст өгөх өлөг			
<b>Дүн</b>	<b>0</b>	<b>12,722.3</b>	<b>12,722.3</b>

*Эх сурвалж: Могод сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд засаг даргын нөөц хөрөнгийн шатахууны гүйлгээ нь төрийн сангийн системд хийгдээгүйтэй холбоотой өр үүссэн, сургуулийн халаалтын зардлын төсөв хүрэлцэхгүйтэй холбоотой 11,337.0 төгрөгийг өр үүссэн байна.

### 3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,340,737.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 2,176,866.3 мянган төгрөг болж, 2,163,870.9 мянган төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт № 31. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт/+, бууралт /-/</u>
<u>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</u>	1,208,784.1	258,699.9	0
<u>Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/</u>			
<u>Хуримтлагдсан үр дүн</u>	1,689,534.8	1,768,101.3	
<u>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</u>	1,442,418.3	150,065.1	
<u>Бодлогын өөрчлөлт алдааны залруулга</u>			
<b>Дүн</b>	<b>4,340,737.20</b>	<b>2,176,866.3</b>	<b>-2,163,870.9</b>

*Эх сурвалж: Могод сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4340737.2 мянган төгрөг эцсийн үлдэгдэл 2,176,866.3 болж 2,163,870.9 мянган төгрөгөөр буурсан нь тусгай шилжүүлгийн байгууллагууд орон нутгийн төсвөөс хасагдсантай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн орлогоос 320,877.0, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 513,517.7, ОНХС-аас 134,465.8, төсвийн байгууллагын үйл ажиллагааны орлогоос 40,000.0 мянган төгрөг нийт зарлагыг 1,204,616.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн орлогоос 320,877.0, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 513,517.7, ОНХС-аас 134,465.8, төсвийн байгууллагын үйл ажиллагааны орлогоос 40,000.0 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн орлогоос 327153.8, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 505217.7, ОНХС-аас 134,465.8, төсвийн байгууллагын үйл ажиллагааны орлогоос 110745.7 нийт 1159396.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,005,028.8 мянган төгрөг буюу 83.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагаа зардлын төсвөөс цалин хөлсийг 13913.0, бараа үйлчилгээний зардлыг 2799.3, хөрөнгийг зардал буюу ОНХС-гаас 175,333.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Ерөнхий боловсрол	165,092,600.00	164,985,027.08	107,572.9	99.9%
2	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	78,290,300.00	71,187,263.75	7,103,036.3	90.9%
3	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	430,628,500.00	416,557,301.90	14,071,198.1	96.7%
4	Соёл урлаг	26,340,100.00	26,339,985.25	114.8	99.9%
5	Сургуулийн өмнөх боловсрол	33,575,500.00	33,575,406.81	93.2	100.0%
6	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	36,492,000.00	35,509,685.75	982,314.3	97.3%
7	Сумын ОНХС	339,197,000.00	163,863,900.00	175,333,100.0	48.3%
8	Сум хөгжүүлэх сан	70,000,000.00	66,139,277.00	3,860,723.0	94.5%
9	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан	25,000,000.00	26,871,000.00	-1,871,000.0	107.0%
	Нийт дүн	1,204,616.0	1,005,028.8	199,587.1	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар сумын ЗДТГ-т 3 түмэн адууны баярт зориулсан иргэдийн хандив 29399.5, аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөс сумын ЗДТГ-т Цэвэр орчин цэмцгэр Булган аяны 1500.0, урьд оны үлдэгдэл 4798.8, ИТХ-д 300.0, дээд шатны төсөв

захирагчаас малын тооллогод 3,782.9, үйл ажиллагааны хүрээнд “Булган мээж” ХХК-аас 3 худгийн усны төлбөр, ухаалаг худгийн усны төлбөр зэрэг 6,156.6 нийт 45,937.9 мянган төгрөгийн орлого төвлөрч зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Могод сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах 2 холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Содном гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Могод сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 01/36 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

##### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 1,204,616.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 18,069.2 төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

##### **4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага арга хэмжээ авч ажилласан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,005,028.8 мянган төгрөг буюу 83.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагаа зардлын төсвөөс цалин хөлсийг 13913.0, бараа үйлчилгээний зардлыг 2799.3, хөрөнгийг зардал буюу ОНХС-гаас 175,333.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэлт үүссэн байна.

##### **4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

#### 4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд 28 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх"; 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"; гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.7.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитыг хийгээгүй.

##### 4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар малын тоо толгойн албан татварын дутуу 10643.7 мянган төгрөгийн төлбөрийн акт, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг хүргүүлж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 01/269 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

*Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	10643.7	1	10643.7	100
Албан шаардлага	0	0	0	0	
Зөвлөмж	3	220765,7	3	220765,7	100
<b>Нийт дүн</b>					

#### 4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сумын орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 22,207.2 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 16,930.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 5276.8 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

Сумын ИТХ-ын тогтоолоор малын тоо толгойн албан татварыг тогтоосон, 2021 оны жилийн эцсийн малын тоо толгойгоор тооцож үзэхэд 108730.4 мянган төгрөгийг татварыг төсөвт төвлөрүүлэхээр байгаа боловч орон нутгийн орлогод 91800.0 мянган төгрөгийг

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



